

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ХҮСЧ БАЙГАА БОЛОН СУНГУУЛАХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлийг олгох болон сунгахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийг баримтлан олгодог болно.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ХҮСЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС:

Тусгай зөвшөөрөл шинээр хүссэн хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд заасан тавигдах шаардлагыг хангаж, бүрдүүлэх баримт бичгийг бүрэн ирүүлнэ.

Тавигдах шаардлага:

1. Үүсгэн байгуулагч нь татварын мэргэшсэн зөвлөх байх;
2. Гурав, түүнээс доошгүй тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх;
3. Үйл ажиллагаагаа явуулах ажлын байр, техник хэрэгсэл, программ хангамжтай байх;
4. Үйл ажиллагаандаа ашиглах гарын авлага, аргачлал, арга зүйгээр хангагдсан байх;
5. Зөвлөх үйлчилгээний ажлын баримтыг хадгалах зориулалтын архивтай байх;
6. Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
7. Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээд салбартай бол түүнд хоёр, түүнээс доошгүй орон тооны татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч ажиллуулах;

Бүрдүүлэх материал:

1. Зөвлөх үйлчилгээ эрхлэхийг хүссэн этгээдийн өргөдөл;
2. Үүсгэн байгуулагчийн анкет;
3. Үүсгэн байгуулах хурлын шийдвэр;
4. Хуулийн этгээдийн дүрэм;
5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
6. Үүсгэн байгуулагчийн татварын өргүй болохыг нотолсон эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
8. Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн албан бичиг хавсаргах;
9. Хуульд заасан тавигдах шаардлагыг нотлох баримт, бичиг;

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС:

Бүрдүүлэх материал:

1. Зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сунгуулах хуулийн этгээдийн өргөдөл;
2. Үүсгэн байгуулагчийн анкет;
3. Хуулийн этгээдийн дүрэм;
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
5. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
6. Хуулийн этгээдийн татварын өргүй болохыг нотолсон эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
7. Хуулийн этгээдэд ажиллах гурав, ба түүнээс доошгүй тооны татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хүмүүсийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
8. Холбогдох этгээдүүдийн нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар төрийн үйлчилгээний цахим системийн лавлагаа;
9. Үйл ажиллагаагаа явуулах ажлын байрны түрээсийн гэрээ, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар;
10. Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн албан бичиг хавсаргах;
11. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ эх хувиараа;

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсэх болон сунгуулахаар бүрдүүлсэн баримт, бичигээ Сангийн яамны НБББГ-ын Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэнээр хянуулан, шаардлага хангасан гэж үзэл яамны бичиг хэрэгт хүлээлгэн өгнө.

-----oO-----